

Өөрийгөө сорьж мэдлэгээ бататгаарай
5, 2, 4, -3, -5, -1 тоонуудыг шулуун дээр тэмдэглээрэй.

Жишээрэй.

-6 +1, 0 -2, 9 -9, -10 -20

Тоонуудыг багаас нь их рүү эрэмбэлэн бичээрэй.

-14, +1, +8, -1, 0, +6, +19, -22, -7

b ба 43-ын арифметик дундаж 35 болно. b тоог олоорой.

A. 78

B. 27

C. 39

D. 16

Хоёр тооны арифметик дундаж 1620-той тэнцүү. Нэг тоо нь нөгөөгөөс 4 дахин их бол эдгээр тоонуудыг олоорой.

Зарим саруудын агаарын хэмийг графикаар харуулав. Дээрх саруудын агаарын хэмийн дунджийг олоорой.




A. 11°

B. 10°

C. 1°

D. 25°

Сурагчдаас ямар төрлийн кинонд дуртайг нь тодруулахаар судалгааг хийжээ. Судалгааны үр дүнг дараах диаграммаар харуулав. Үүнийг ашиглан арифметик дунджийг ол.



Явган аялагчид эхний өдөр 1.8 км, II дахь өдөр 2.6 км, III дахь өдөр 2.5 км явсан бол өдөрт дунджаар хэдэн километр явсан бэ?

A. 6.9 км

B. 6900м

C. 4.4 км


D. 2.3 км

Дарааллын зүй тогтлыг илрүүлж дараагийн хоёр гишүүнийг бичээрэй.
1, 6, 4, 9, 7, ..., ...

Квадратын талбай 49м.кв. Түүний талыг 2м -ээр багасгавал талбай нь хэдэн м.кв-аар багасах вэ?

Тэгш өнцөгтийн талбай нь 882кв.м. Нэг тал нь 63 м бол энэ тэгш өнцөгтийн периметрийг олоорой.

Дараах зураг дээр дүрслэгдсэн хэсэг газрын талбайг олоорой. (Хэмжээ метрээр өгөгдсөн)



A. 17600 м.кв

B. 18800 м.кв

C. 1200 м.кв

D. 16400 м.кв

Тэгш өнцөгтийн урт ба өргөний нийлбэр 40 см бол хүрээний урт хэд вэ? Квадратын хүрээний урт 80 см бол талбай хэд вэ?

Дараах өгөгдлүүдийн медианыг олоорой.

5.4; 2.6; 7.3; 1.2; 3.5

A. 3.5

B. 2.6

C. 7.3

D. 1.2